

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/020/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн "ЦЭБЭ Консалтинг аудит" ХХК-ийн
захирал Д.Энхбаатар

Утас: 77114235 Цахим хаяг: audit@tsebeconsulting.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tiv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2026.01.25 № 01/230
танай _____-ны № _____-т

**ТӨВ АЙМГИЙН БАЯН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Г.БАТСАЙХАН ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Төв аймгийн Баян сумын Засаг даргын 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/110 дугаар захирамжийг үндэслэн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын зардлаар хийж гүйцэтгэсэн 2,715,156.1 мянган төгрөгийн үнэ бүхий спорт заалыг сургуулийн захирлын 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэж орлогод авсан байна.

Аудитын гол асуудал

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус "бараа үйлчилгээний бусад зардал" гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийн зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

G/Arkhiw/Alban bichig 2026/A4

• 4126020518

Бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургууль нь гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 90.4 %-тай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		228,781,961.35	283,850,492.89
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	4	185,389,132.35	224,104,413.89
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		185,389,132.35	224,104,413.89
31210	Төгрөг		185,389,132.35	224,104,413.89
31211	Төрийн сангийн харилцах		185,389,132.35	224,104,413.89
35	БАРАА МАТЕРИАЛ		43,392,829.00	59,746,079.00
351	Түүхий эд материал	6	410,000.00	410,000.00
35110	Тусгай зориулалттай материал		410,000.00	410,000.00
354	Хангамжийн материал		42,982,829.00	59,336,079.00
35410	Бичиг хэргийн материал		367,800.00	4,970,800.00
35420	Аж ахуйн материал		11,603,005.00	13,185,005.00
35460	Хүнсний материал		197,360.00	-
35470	Бусад хангамжийн материал		30,814,664.00	41,180,274.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,746,764,457.14	4,536,626,222.33
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	1,746,764,457.14	4,536,626,222.33
392	Биет хөрөнгө		1,689,145,457.14	4,479,131,522.35
39201	Барилга, байгууламж, орон сууц		1,603,294,882.00	4,486,648,882.00
39202	Хуримтлагдсан элэгдэл		(258,335,428.70)	(300,515,340.98)
39203	Авто-тээврийн хэрэгсэл		6,450,000.00	6,450,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		(6,450,000.00)	(6,450,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		247,184,127.00	260,213,967.00
39206	Хуримтлагдсан элэгдэл		(91,902,162.62)	(126,471,900.34)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		92,327,859.17	96,618,566.77
39208	Хуримтлагдсан элэгдэл		(36,424,497.92)	(49,488,384.29)
39214	Бусад үндсэн хөрөнгө		206,071,743.52	205,830,589.14
39215	Хуримтлагдсан элэгдэл		(73,071,065.31)	(93,704,856.95)
393	Биет бус хөрөнгө		57,619,000.00	57,494,699.98
39301	Программ хангамж		1,243,000.00	1,243,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		-	(124,300.02)
39303	Бусад биет бус хөрөнгө		56,376,000.00	56,376,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		1,975,546,418.49	4,820,476,715.22
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		-	682,084.49

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		-	682,084.49
413	Өглөг		-	682,084.49
41360	Бусад өглөг		-	682,084.49
41361	Байгууллагад төлөх өглөг		-	682,084.49
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		1,975,546,418.49	4,819,794,630.73
51	Засгийн газрын хувь оролцоо		1,975,546,418.49	4,819,794,630.73
511	Засгийн газрын оруулсан капитал		242,035,023.90	242,035,023.90
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		242,035,023.90	242,035,023.90
512	Хуримтлагдсан үр дүн		1,139,537,202.30	3,983,785,414.54
51210	Өмнөх үеийн үр дүн		1,158,349,901.67	1,139,537,202.30
51220	Тайлант үеийн үр дүн		(18,812,699.37)	2,844,248,212.24
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		593,974,192.29	593,974,192.29
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		1,975,546,418.49	4,820,476,715.22

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2	1,557,732,643.22	4,720,611,754.12
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		102,628,143.22	4,720,611,754.12
120	Нийтлэг татварын бус орлого		102,628,143.22	2,909,765,354.12
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого		-	1,341,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		-	1,341,100.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – үндсэн хөрөнгө		99,430,713.22	2,894,919,254.12
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		3,197,430.00	13,505,000.00
122	Тусламж, санхүүжилтийн орлого		-	1,810,846,400.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого		-	1,810,846,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,455,104,500.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		1,239,403,600.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		1,239,403,600.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		215,700,900.00	-

Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		215,700,900.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (2)	3	1,526,829,935.20	1,876,363,541.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,526,829,935.20	1,876,363,541.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,478,162,894.00	1,801,958,064.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		912,914,183.94	1,116,320,018.19
210101	Үндсэн цалин		577,162,037.16	674,239,913.28
210102	Нэмэгдэл		292,913,779.28	378,318,715.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт		-	23,065,000.00
210104	Урамшуулал		42,838,367.50	40,696,389.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		110,316,118.77	136,824,581.27
210201	Тэтгэврийн даатгал		74,319,003.29	95,010,950.10
210202	Тэтгэмжийн даатгал		9,238,748.05	11,164,662.57
210203	ҮОМШӨ-ний даатгал		4,734,685.13	5,834,856.53
210204	Ажилгүйдлийн даатгал		4,207,650.52	5,165,371.04
210205	Эрүүл мэндийн даатгал		17,816,031.78	19,648,741.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		208,459,835.80	315,664,413.05
210301	Гэрэл, цахилгаан		9,782,104.38	15,606,072.50
210302	Түлш, халаалт		197,571,231.42	297,138,840.55
210303	Цэвэр, бохир ус		1,106,500.00	2,919,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал		11,328,553.00	631,500.00
210401	Бичиг хэрэг		1,148,000.00	631,500.00
210402	Тээвэр, шатахуун		371,000.00	-
210408	Бараа материал акталсны зардал		9,809,553.00	-
2105	Нормативт зардал		32,982,430.00	40,345,939.00
210502	Хоол, хүнс		32,982,430.00	40,345,939.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		2,996,700.00	24,999,550.00
210604	Урсгал засвар		2,996,700.00	24,999,550.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		20,588,616.53	20,762,384.49
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		-	1,891,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		1,152,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		19,436,616.53	18,871,284.49
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		178,576,455.96	146,409,678.93

Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210901	Бараа ажил үйлчилгээний бусад зардал		19,451,530.00	1,280,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		9,217,890.00	6,077,190.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		149,907,035.96	139,052,488.93
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		48,667,041.20	74,405,476.95
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		-	11,789,036.95
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг		-	11,789,036.95
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		-	11,789,036.95
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		-	11,789,036.95
2132	Бусад урсгал шилжүүлэг		44,422,677.00	62,616,440.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		39,566,477.00	62,616,440.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		4,856,200.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		4,244,364.20	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		4,244,364.20	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	4	30,902,708.02	2,844,248,212.24
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		49,715,407.39	-
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз		49,715,407.39	-
7	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (7)=(4)-(5)		(49,715,407.39)	-
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (6)=(3)+(7)	6	(18,812,699.37)	2,844,248,212.24

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН		1,455,104,500.00	1,810,846,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		-	1,810,846,400.00
122	Тусламж, санхүүжилтийн орлого		-	1,810,846,400.00
1221	Тусламж, санхүүжилт		-	1,810,846,400.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого		-	1,810,846,400.00

Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,455,104,500.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		1,239,403,600.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		1,239,403,600.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		215,700,900.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		215,700,900.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (2)		1,370,126,056.24	1,758,126,118.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,370,126,056.24	1,758,126,118.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,320,670,425.04	1,683,802,741.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		911,595,415.17	1,116,320,018.19
210101	Үндсэн цалин		546,863,734.33	633,976,388.51
210102	Нэмэгдэл		316,244,934.71	408,933,476.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт		-	21,359,332.74
210104	Урамшуулал		48,486,746.13	52,050,820.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		111,634,887.54	136,824,581.27
210201	Тэтгэврийн даатгал		75,906,626.65	93,672,557.82
210202	Тэтгэмжийн даатгал		9,054,362.31	11,098,785.39
210203	ҮОМШӨ-ний даатгал		4,549,251.31	5,797,862.60
210204	Ажилгүйдлийн даатгал		4,424,849.47	5,298,304.41
210205	Эрүүл мэндийн даатгал		17,699,797.80	20,957,071.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		208,459,835.80	315,664,413.05
210301	Гэрэл, цахилгаан		9,782,104.38	15,606,072.50
210302	Түлш, халаалт		197,571,231.42	297,138,840.55
210303	Цэвэр, бохир ус		1,106,500.00	2,919,500.00
2105	Нормативт зардал		29,680,800.00	40,230,679.00
210502	Хоол, хүнс		29,680,800.00	40,230,679.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		2,996,700.00	24,999,550.00
210604	Урсгал засвар		2,996,700.00	24,999,550.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		11,943,816.53	19,334,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		11,943,816.53	19,334,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		44,358,970.00	30,429,400.00

Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал		35,338,970.00	24,093,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		9,020,000.00	6,335,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		49,455,631.20	74,323,376.95
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		4,244,364.20	11,789,036.95
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг		4,244,364.20	11,789,036.95
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		4,244,364.20	11,789,036.95
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		4,244,364.20	11,789,036.95
2132	Бусад урсгал шилжүүлэг		45,211,267.00	62,534,340.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		40,355,067.00	62,534,340.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		4,856,200.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		4,244,364.20	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		4,244,364.20	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)		84,978,443.76	52,720,281.54
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН		14,903,100.00	14,005,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		14,903,100.00	14,005,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр		14,903,100.00	14,005,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		14,903,100.00	14,005,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		(14,903,100.00)	(14,005,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		70,075,343.76	38,715,281.54
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		115,313,788.59	185,389,132.35
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		185,389,132.35	224,104,413.89

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	242,035,023.90	599,664,345.75	1,152,659,748.21	1,994,359,117.86
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	5,690,153.46	5,690,153.46
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	242,035,023.90	599,664,345.75	1,158,349,901.67	2,000,049,271.32
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(5,690,153.46)	-	(5,690,153.46)
Тайлант үеийн үр дүн	-	-	(18,812,699.37)	(18,812,699.37)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	242,035,023.90	593,974,192.29	1,139,537,202.30	1,975,546,418.49
Тайлант үеийн үр дүн	-	-	2,844,248,212.24	2,844,248,212.24
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	242,035,023.90	593,974,192.29	3,983,785,414.54	4,819,794,630.73

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,478,041,600.00	1,458,393,400.00	(19,648,200.00)	98.7
12	Татварын бус орлого	1,478,041,600.00	1,458,393,400.00	(19,648,200.00)	98.7
120	Нийтлэг татварын бус орлого	1,341,100.00	-	(1,341,100.00)	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого /үндсэн/	1,341,100.00	-	(1,341,100.00)	-

Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

122	Тусламж, санхүүжилтийн орлого	1,476,700,500.00	1,458,393,400.00	(18,307,100.00)	98.8
122005	Төсвөөс санхүүжих	1,476,700,500.00	1,458,393,400.00	(18,307,100.00)	98.8
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,657,356,900.00	1,419,678,118.46	(237,678,781.54)	85.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,657,356,900.00	1,419,678,118.46	(237,678,781.54)	85.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,589,730,100.00	1,357,143,778.46	(232,586,321.54)	85.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,313,091,900.00	1,116,320,018.19	(196,771,881.81)	85.0
210101	Үндсэн цалин	825,816,500.00	633,976,388.51	(191,840,111.49)	76.8
210102	Нэмэгдэл	463,952,800.00	408,933,476.43	(55,019,323.57)	88.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	21,359,332.74	21,359,332.74	-
210104	Урамшуулал	23,322,600.00	52,050,820.51	28,728,220.51	223.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	164,136,500.00	136,824,581.27	(27,311,918.73)	83.4
210201	Тэтгэврийн даатгал	111,612,800.00	93,672,557.82	(17,940,242.18)	83.9
210202	Тэтгэмжийн даатгал	13,130,900.00	11,098,785.39	(2,032,114.61)	84.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,565,500.00	5,797,862.60	(767,637.40)	88.3
210204	Ажилгүйдлийн даатгал	6,565,500.00	5,298,304.41	(1,267,195.59)	80.7
210205	Эрүүл мэндийн даатгал	26,261,800.00	20,957,071.05	(5,304,728.95)	79.8
2105	Нормативт зардал	47,035,100.00	40,230,679.00	(6,804,421.00)	85.5
210502	Хоол, хүнс	47,035,100.00	40,230,679.00	(6,804,421.00)	85.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,917,500.00	19,334,100.00	(1,583,400.00)	92.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн болон нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,341,100.00	-	(1,341,100.00)	-
210806	Мэдээллийн технологийн зардал	19,576,400.00	19,334,100.00	(242,300.00)	98.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,549,100.00	44,434,400.00	(114,700.00)	99.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,213,400.00	38,098,700.00	(114,700.00)	99.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,335,700.00	6,335,700.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,626,800.00	62,534,340.00	(5,092,460.00)	92.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	67,626,800.00	62,534,340.00	(5,092,460.00)	92.5

Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	67,626,800.00	62,534,340.00	(5,092,460.00)	92.5
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(179,315,300.00)	38,715,281.54	-	-
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	179,315,300.00	(38,715,281.54)	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	185,389,132.35	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	224,104,413.89	-	-

2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	352,453,000.00	340,663,963.05	(11,789,036.95)	96.7
12	Татварын бус орлого	352,453,000.00	340,663,963.05	(11,789,036.95)	96.7
122	Тусламж, санхүүжилтийн орлого	352,453,000.00	340,663,963.05	(11,789,036.95)	96.7
122005	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	352,453,000.00	340,663,963.05	(11,789,036.95)	96.7
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	352,453,000.00	340,663,963.05	(11,789,036.95)	96.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	352,453,000.00	340,663,963.05	(11,789,036.95)	96.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	352,453,000.00	340,663,963.05	(11,789,036.95)	96.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	327,453,000.00	315,664,413.05	(11,788,586.95)	96.4
210301	Гэрэл, цахилгаан	15,606,100.00	15,606,072.50	(27.50)	100.0
210302	Түлш, халаалт	308,927,400.00	297,138,840.55	(11,788,559.45)	96.2
210303	Цэвэр, бохир ус	2,919,500.00	2,919,500.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,000,000.00	24,999,550.00	(450.00)	100.0
210604	Урсгал засвар	25,000,000.00	24,999,550.00	(450.00)	100.0
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-		

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Залруулсан алдаа

Аудитаар нийт 238,449.4 мянган төгрөгийн 5 алдаа¹ илэрснээс Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу аудитын явцад 4 залруулга хийлгэлээ. Үүнд:

- Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой шинэчлэн батлагдсан заавар журмуудын дагуу НБББББ-ыг шинэчилээгүй.
- Боловсролын сайдын 2025.08.20-ны А/417 дугаар тушаалын дагуу 2 ширхэг ангийн самбарыг үнэ төлбөргүй хүлээж авсан орлогоор аваагүй, Санхүүгийн үр дүнгийн тайланд тусгаагүй.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд улсын төсвийн санхүүжилтийн эх үүсвэрийг 197,622.4 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн урсгал зардлын төлөвлөгөөг 22,265.2 мянган төгрөгөөр тус тус бууруулж тайлагнасан.
- Мөнгөн гүйлгээний тайлан, үндсэн хөрөнгийн тодруулгын тайланд төсвийн хөрөнгөөр худалдан авч бэлтгэсэн үндсэн хөрөнгийг хөрөнгийн зардлаар тохируулж тайлагнаагүй.
- Бараа материалын дансанд 3,156.9 мянган төгрөгийн тээвэр шатахууны зардлыг бараа материал худалдсаны зардалд бичиж, санхүүгийн үр дүнгийн тайланд тайлагнагдаагүй байна.

Эдгээр алдаанууд нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-т “үнэн зөв байх”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 329 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт, НББ-ийн Үнэн зөв байх “Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэнэ”, Тогтвортой байх “Нэг үеэс нөгөө үед зэрэгцүүлэх боломжтой байх үүднээс бүртгэлийн арга, сууриа тогтвортой баримтлах хэрэгтэй” зарчимтай нийцээгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар илэрсэн нийт 3,630.9 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 17,156.9 мянган төгрөгөөр бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Аудитаар нийт 3,630.9 мянган төгрөгийн 7 зөрчил² илэрсэнд, нийцлийн аудитын 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, төсөвт төвлөрүүлэх 3 төлбөрийн акт тогтоож, 3 зөвлөмж өглөө.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

5.1 Төлбөрийн акт

1.Илрүүлэлт: Нийгмийн даатгалын шимтгэлийн алданги 201.0 мянган төгрөг, актийн төлбөр 100.5 мянган төгрөг, нийт 301.5 мянган төгрөгийг байгууллагын төсвөөс төлсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;”, 20.2.7-д “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах;” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн.” бол төлбөрийн акт тогтооно гэж заасны дагуу шийдвэрлэв.

2.Илрүүлэлт: Захирлын 2025 оны Б/08 дугаар тушаалаар сахилгын арга хэмжээ авсан ажилтанд 429,300.00 /дөрвөн зуун хорин емөн мянга гурван зуун/ төгрөгийн үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”, Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8-д “Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно.”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.2.2-д “төсвийн шууд захирагч нь байгууллагын төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно”, 3 дугаар хавсралтын 2 дугаар зүйлийн 2.7-д “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй.” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн.” гэж заасны дагуу шийдвэрлэв.

3.Илрүүлэлт: Сургуулийн захирлын 2025 оны А/01 дугаар тушаалаар Нягтлан бодогчийн цалинг Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын цалингийн сүлжээнээс илүү тогтоосон, үр дүнгийн мөнгөн урамшуулал, балансын шагнал, нийт 1,559.0 мянган төгрөгийг давхардуулан олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.7-д "төрөөс хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, хөтөлбөр, арга хэмжээ, татвар ногдуулалт, эсхүл хөнгөлөлт, баталгаа, зээл, өр төлбөр, санхүүгийн үйл ажиллагаа, болзошгүй өр төлбөр, тэдгээрийн үр дүн нь өнөө болон ирээдүй үеийн хооронд тэгш бус байдал үүсгэхгүй байх", Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын 10 дугаар хавсралт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-д "үнэн зөв байх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн." бол төлбөрийн акт тогтооно гэж заасны дагуу шийдвэрлэв.

5.1 Зөвлөмж

1.Илрүүлэлт: Сургуулийн дунд, ахлах ангийн суралцагчдад сурах бичгийг сургуулийн номын сангаар төлбөртэй үйлчилж олсон орлогыг туслах үйл ажиллагааны орлогоор тайлагнаж зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 6.2.5-д "төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх", 6.3.1-д "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах", 6.4.6-д "хуульд өөрөөр заагаагүй бол төсвийн орлогыг аль нэг этгээд, эсхүл үйл ажиллагаанд тусгайлан оноохгүй байх" заалтууд болон "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлэв.

2.Илрүүлэлт: Захирлын 2025 оны А/22 дугаар тушаалаар жилийн эцсийн тооллого хийсэн боловч тооллогын дүнгээр тооцоо бодсон акт үйлдэж, үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг баталгаажуулаагүй, удирдлагад тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д

“хариуцлагатай байх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-д “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана” гэсэн заалтууд болон “тасалбар болголт”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тооллогын бүртгэлийг үндэслэн тооллогын дүнгээр тооцоо бодсон акт үйлдэж, үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг баталгаажуулж хэвших зөвлөмж өгөв.

3.Илрүүлэлт: Үдийн цай, хүнсний материалын захиалгын хуудас, зарцуулалтын бүртгэл, тайлан баталгаажуулалтгүй, хяналт хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-д “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.”, 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах,” заалтууд болон “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хүчин төгөлдөр баримтыг үндэслэн ажил, гүйлгээ хийж, хяналт тавьж ажиллах зөвлөмж өгөв.

Дээрх зөрчлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд хүргүүлж, хэрэгжилтийн биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 238,449.4 мянган төгрөгийн 5 алдаа³ илэрснээс Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу аудитын явцад 4 залруулга хийлгэлээ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл*/мянган төгрөгөөр/*

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой шинэчлэн батлагдсан заавар журмуудын дагуу НБББББ-ыг шинэчилээгүй байна.	1	-			1	-			1	-		
Боловсролын сайдын 2025 оны А/417 дугаар тушаалын дагуу 2 ширхэг ангийн самбарыг үнэ төлбөргүй хүлээж авсан орлогоор аваагүй, Санхүүгийн үр дүнгийн тайланд тусгаагүй.	1	1,400.0	1	1,400.0			1	1,400.0				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд улсын төсвийн санхүүжилтийн эх үүсвэрийг 197,622.4 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн урсгал зардлын төлөвлөгөөг 22,265.2 мянган төгрөгөөр тус тус бууруулж тайлагнасан.	1	219,887.6			1	219,887.6	1	219,887.6				
Мөнгөн гүйлгээний тайлан, үндсэн хөрөнгийн тодруулгын тайланд төсвийн хөрөнгөөр худалдан авч бэлтгэсэн үндсэн хөрөнгийг хөрөнгийн зардлаар тохируулж тайлагнаагүй.	1	14,005.0			1	14,005.0	1	14,005.0				
Бараа материалын дансанд 3,156.9 мянган төгрөгийн тээвэр шатахууны зардлыг бараа материал худалдсаны зардалд бичиж, санхүүгийн үр дүнгийн тайланд тайлагнагдаагүй байна.	1	3,156.9			1	3,156.9	1	3,156.9				
Дүн	5	238,449.5	1	1,400.0	4	237,049.5	4	238,449.5	1	-		

³ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

3.2 Аудитаар нийт 3,630.9 мянган төгрөгийн 7 зөрчил⁴ илэрсэнд, нийцлийн аудитын 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, төсөвт төвлөрүүлэх 3 төлбөрийн акт тогтоож, 3 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нийгмийн даатгалын шимтгэлийн алданги 201.0 мянган төгрөг, актийн төлбөр 100.5 мянган төгрөг, нийт 301.5 мянган төгрөгийг байгууллагын төсвөөс төлсөн байна.	1	301.5	1	301.5								
Захирлын 2025 оны Б/08 дугаар тушаалаар сахилгын арга хэмжээ авсан ажилтанд 429.3 мянган төгрөгийн үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон байна.	1	429.3	1	429.3								
Сургуулийн захирлын 2025 оны А/01 дугаар тушаалаар Нягтлан бодогчийн цалинг Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын цалингийн сүлжээнээс илүү тогтоосон, үр дүнгийн мөнгөн урамшуулал, балансын шагнал, нийт 1,559.0 мянган төгрөгийг давхардуулан олгосон байна.	1	1,559.0	1	1,559.0								
Сургуулийн дунд, ахлах ангийн суралцагчдад сурах бичгийг сургуулийн номын сангаар төлбөртэй үйлчилж олсон орлогыг туслах үйл ажиллагааны орлогоор тайлагнаж зарцуулсан байна.	1	1,341.1					1	1,341.1				
Захирлын 2025 оны А/22 дугаар тушаалаар жилийн эцсийн тооллого хийсэн боловч тооллогын дүнгээр тооцоо бодсон акт үйлдэж, үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг баталгаажуулаагүй, удирдлагад тайлагнаагүй байна.	1	-					1	-				
Үдийн цай, хүнсний материалын захиалгын хуудас, зарцуулалтын бүртгэл, тайлан баталгаажуулалтгүй, хяналт хэрэгжүүлээгүй байна.	1	-					1	-				
Дүн	6	3,630.9	3	2,289.8			3	1,341.1				

⁴ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар 1 зөрчил илэрч, зөрчилд 1 албан шаардлага өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбогдсон өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн, ойлгомжтой, ач холбогдолтой байх зарчмуудыг хангаж ажиллаагүй байна	1	-			1	-		
Дүн	1	-			1	-		

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn